



АРХАНГАЙ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ХҮН АМЫН АМЬДАРЧ БУЙ ОРЧИН, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ



2019-ОН

АГУУЛГА

Архангай аймгийн товч танилцуулга.....	3
Аймгийн нийгэм, эдийн засгийн товч мэдээлэл, 2018 оны байдлаар.....	4
Өрхийн орон сууцны нөхцөл	5
Сурч боловсрох нөхцөл.....	7
Эрүүл мэндийн нөхцөл.....	8
Аюулгүй байдал.....	9
Хүн амын нийгмийн үзүүлэлт.....	11

АРХАНГАЙ АЙМГИЙН ТАНИЛЦУУЛГА

Архангай аймаг нь Монгол орны Хангайн бүсийн төв хэсэгт оршдог 55,3 мянган км² нутагтай, 19 сум 101 багтай. Засаг захиргааны нэгж, хүн ам, малын тоогоор манай томоохон аймгийн тоонд орно. Архангай аймгийн ихэнх сум өндөр уул, ойт хээрийн бүсэд хамрагдах бөгөөд зөвхөн Хашаат, Өлзийт, Өгийнуур сум тал хээрийн бүсэд орно. Аймгийн нийт нутгийн 67,6 хувийг бэлчээр, 1.0 хувь хадлангийн талбай, 0.4 хувь тариалангийн талбай, 15.3 хувийг ой эзэлдэг. Манай улсын нийт ойн талбайн 7.0 хувийг тус аймаг эзэлдэг.

Аймгийн нийт нутаг далайн түвшнээс 1200-3600 метрийн өндөрт өргөгдсөн, төрийн тахилгат Суврага хайрхан болон Цогт сүмбэр, Харлагтай, Ноён хангай, Хан-Өндөр зэрэг сүрлэг сайхан уулс, Орхон, Тамир, Хануй, Хүнүй, Чулуут зэрэг гол мөрөн, Тэрхийн цагаан, Өгий, Холбоо, Дөрөө зэрэг цэнгэг уст нууруудтай.

Тус аймаг нь манай орны байгалийн нөхцөл, цаг уурын хувьд хамгийн тааламжтайд тооцогдох хангайн бүсэд хамрагдана. Мал аж ахуйг нийт сумдад өсгөн үржүүлэх, газар тариаланг Төвшрүүлэх зэрэг зарим суманд эрхлэн хөгжүүлэх бүрэн боломжтой юм. Ой мод, урсгал усны асар их нөөцтэй, шатдаг занар, төмрийн хүдэр, зэс, хар, цагаан тугалга, мана, гантиг, утаат болон усан болор, хайлуур жонш зэрэг ашигт малтмалын нөөц бүхий ордтой.

Хөдөө аж ахуй бол аймгийн эдийн засгийн үндсэн салбар юм. Тус аймаг нийт 410.0 тэрбум төгрөгийн дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсний 63.8 хувь нь хөдөө аж ахуйд, 13.5 хувь нь аж үйлдвэр, барилгын салбарт ногдож байна. Аймгуудын дотоодын нийт бүтээгдэхүүний 1.6 хувийг тус аймагт үйлдвэрлэдэг.

Аймгийн бүх сум эрчим хүчний нэгдсэн сүлжээнд бүрэн хамрагдаж, нийслэлээс 477 км алслагдсан аймгийн төв Цэцэрлэг хот хатуу хучилттай хар замаар Улаанбаатар хоттой холбогдсон.

АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ 2018 ОНЫ БАЙДЛААР

Хүн ам 2018 оны эцэст манай аймагт урьдчилсан дүнгээр 27.9 мянган өрх, 95.9 мянган хүн амтай байна. Нийт хүн амын 49.9 хувийг эмэгтэйчүүд эзэлж хүйсийн харьцаа 100.4 байна.

Өрх хүн амыг байршлаар нь авч үзвэл нийт өрхийн 18.2 хувь нь буюу 5.4 мянган өрхийн 17.5 мянган хүн сумын төвд, 23 хувь буюу 6.1 мянган өрхийн 22.1 мянган хүн аймгийн төвд оршин сууж байна.

Боловсрол 2018 - 2019 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 33 сургуулийн 654 бүлэгт 17.1 мянган хүүхэд суралцаж, 36 цэцэрлэгт 7.4 мянган хүүхэд хүмүүжиж байна.

Эрүүл мэнд Эмнэлгийн байгууллагууд 518 ор, амбулаторийн 111 их эмчтэйгээр хүн амд үйлчилж давхардсан тоогоор 308.3 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсний 115.5 мянган хүнд урьдчилан сэргийлэх үзлэг хийж 20.8 мянган хүнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж гаргасан байна. Нялхсын буюу 0-1 насны хүүхдийн нас баралт 34 гарч мянган амьд төрөлтөд 20 ногдож байгаа нь өнгөрсөн оныхоос 2 тохиолдлоор нэмэгдсэн байна. олдлоор нэмэгдсэн байна. Аймгийн дүнгээр арван мянган хүн тутмаас 61 нь буюу 582 хүн халдварт өвчнөөр өвчилсөн байгаа бөгөөд Батцэнгэл (111), Эрдэнэбулган(101), Ихтамир(91), Хашаат (74), Жаргалант (70) сумдад аймгийн дунджаас дээгүүр бусад сумдад аймгийн дунджаас доогуур байна. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 1.5 хувь нь гепатит, 22.2 хувь нь салхин цэцгээр, 44.2 хувь нь бэлгийн замын халдварт өвчнөөр, 10.8 хувь нь сүрьеэгээр, 21.3 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилсөн байна. Өнгөрсөн оныхоос халдварт өвчний гаралт 15.6 хувиар буюу 91 тохиолдлоор өссөн байна.

Мал аж ахуй Аймгийн дүнгээр 2018 оны эцэст 5482 мянган мал тоологдсоны дотор 0.02 хувь буюу 1.3 мянга нь тэмээ, 6.9 хувь буюу 378.4 мянга нь адуу, 11.3 хувь буюу 621.2 мянга нь үхэр, 54.4 хувь нь буюу 2981.8 мянга нь хонь, 27.3 хувь буюу 1499.3 мянга нь ямаа байна.

2018 оны эцэст 167 гахай, 80 шувуу, 43 бүл зөгийг иргэд тэжээж бүтээгдэхүүнийг нь авч ашиглаж байна.

Газар тариалан Энэ онд аймгийн дүнгээр 6913.1 га-д үр тариа, 252.4 га-д төмс, 107.3 га-д хүнсний ногоо, 2155 га-д малын тэжээлийн ургамал, 1178 га-д техникийн ургамал тус тус тариалж аймгийн дүнгээр үр тариа 6639.5 тн, төмс 2113.8 тн, хүнсний ногоо 477.8 тн, тэжээлийн ургамал 5817 тн, техникийн ургамал 708.2 тонныг хурааж аваад байна.

Аж үйлдвэр Үйлдвэрийн газрууд 2018 онд оны үнээр 6249.5 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулсан нь өнгөрсөн оныхоос 0.6 хувиар их байна. Зэрэгцүүлэх үнээр үнэлснээр 2355.9 сая төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.4 хувиар өссөн байна. Нийт үйлдвэрлэлтийн 11 хувийг хүнс ундааны, 1.5 хувийг хэвлэлийн, 58 хувийг дулааны эрчим хүчний, 19 хувийг усан хангамж, 4.9 хувийг модон эдлэлийн, 3.4 хувийг барилгын материал, 6.5 хувийг гутал хувцасны, 0.4 хувийг бусад үйлдвэрлэл эзэлж байна.

Барилга Барилгын байгууллагууд 9335.9 сая төгрөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.7 хувиар буурсан байна. Нийт ажлын 83.4 хувь нь барилга угсралтын ажил 16.6 хувь нь их засварын ажил байна.

Орон сууцны нөхцөл

Өрх хүн амыг байршлаар нь авч үзвэл нийт өрхийн 18.2 хувь нь буюу 5.4 мянган өрхийн 17.5 мянган хүн сумын төвд, 23 хувь буюу 6.1 мянган өрхийн 22.1 мянган хүн аймгийн төвд оршин сууж байна.

Сууцны төрөл	2000		2010		2015	
	Өрх	дүнд эзлэх хувь	Өрх	дүнд эзлэх хувь	Өрх	дүнд эзлэх хувь
БҮГД	24396	100	24551	100	26727	100
Гэр	19650	80.5	18062	73.6	19566	73.3
Зориулалтын бус сууц		0	62	0.3	-	-
Бусад		0	2	0	-	-
Байшин	4746	19	6425	26.2	7152	26.7
Орон сууцны байшин		0	493	2	666	2.5
Бие даасан тохилог сууц		0	32	0.1	36	0.1
Сууцны тусдаа байшин	3763	15	5785	23.6	6307	23.6
Нийтийн байр	773	3	115	0.5	143	0.5

* 2000 онд бие даасан тохилог сууцыг тусад нь тодорхойлоогүй

** Оюутан, сурагчдын нийтийн байр, ажиллагчдын нийтийн байр, нийтийн зориулалтын бусад байрыг хамт авч үзэв.

Нийт өрхийн 38.4 хувь нь сууцны тусдаа байшинд, 37.7 хувь нь орон сууцанд, 21.3 хувь нь гэрт, 1.3 хувь нь нийтийн бусад зориулалттай байранд, 1.0 хувь нь бие даасан тохилог орон сууцанд, 0.2 хувь нь бусад сууцанд амьдарч байна. 2000 онтой харьцуулахад орон

сууцанд амьдардаг өрхийн тоо 12.5 хувиар, нийтийн зориулалттай бусад байранд амьдардаг өрхийн тоо 38.2 хувиар, монгол гэрт амьдардаг өрхийн тоо 81.7 хувиар, сууцны тусдаа байшинд амьдардаг өрхийн тоо 2.6 дахин өсч, бусад төрлийн сууцанд амьдардаг өрхийн тоо 69.1 хувиар буурсан байна. 2010 оноос монгол гэрт амьдрах өрхийн тоо тогтворжин, сууцны тусдаа байшинд амьдрах өрхийн тоо 5 жилийн хугацаанд 33.2 хувиар, орон сууцанд амьдардаг өрхийн тоо 12.5 хувиар өссөн байна. 2000-2010 оны хооронд орон сууц нэмж баригдаагүй шилжин ирсэн өрх гэр хороололд шилжин суурьшсанаар 10 жилийн хугацаанд сууцны тусдаа байшинд амьдардаг өрхийн тоо 94.4 хувиар, гэрт амьдардаг өрхийн тоо 79.8 хувиар хурдацтайгаар өссөн байна.

Ахуйн нөхцөл

2015 оны тооллогоор аймгийн нийт өрхийн 38.6 хувь нь төвлөрсөн цахилгаан эх үүсвэрт, 59.6 хувь нь сэргээгдэх эрчим хүчинд холбогдож, цахилгаан эх үүсвэргүй айл өрх 496 буюу 1.8 хувь байна. Өмнөх тооллогын үеийнхээс цахилгааны эх үүсвэргүй өрхийн тоо 1609 өрхөөр буюу 1.8 хувиар буурсан байгаа нь хөдөө орон нутагт сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж, жижиг оврын цахилгаан үүсгүүр өргөн ашиглах болсонтой холбоотой.

Цахилгааны эх үүсвэр	2000		2010		2015	
	Өрх	дүнд эзлэх хувь	Өрх	дүнд эзлэх хувь	Өрх	дүнд эзлэх хувь
Бүгд	24396	100	24487	100	26727	100
Төвлөрсөн систем	8831	36.2	11271	46	10305	38.6
Дизель станц	-	-	-	-	-	-
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	-	-	9921	40.5	15924	59.6
Бага оврын цахилгаан үүсгүүр	-	-	1190	4.8	2	-
Цахилгааны эх үүсвэргүй	15565	63.8	2105	8.6	496	1.8

Ундны усны хангамжийн хувьд 2015 оны тооллогоор нийт өрхийн 2.8 хувь нь төвлөрсөн усан хангамжаар, 97.3 хувь нь төвлөрсөн бус усан хангамжаар ундны усаа уудаг ба 2010 онтой харьцуулахад төвлөрсөн системд холбогдсон усан хангамжтай өрхийн тоо 31.6

хувиар, зөөврийн усан хангамжтай өрхийн тоо 9.6 хувиар өсч, харин бие даасан усан хангамжтай өрхийн тоо 68.9 хувиар буурчээ.

Усан хангамж	2010	2015
БҮГД	24487	26727
Төвлөрсөн усан хангамж	572	753
Халуун, хүйтэн устай	24	66
Зөвхөн хүйтэн устай	548	687
Төвлөрсөн бус усан хангамж	23915	26014
Бие даасан систем	129	40
Халуун, хүйтэн устай	25	17
Зөвхөн хүйтэн устай	104	23
Зөөврийн	23657	25934

Халаалтын эх үүсвэр 2010 онтой харьцуулахад төвлөрсөн системд холбогдсон өрхийн тоо 23.5 хувиар, нам даралтын зуухаар халаадаг өрхийн тоо 26.6 хувиар, ердийн галлагаатай өрхийн тоо 8.6 хувиар тус тус өсч, харин цахилгаан халаагуураар халаадаг өрхийн тоо 9.4 хувиар буурсан байна.

Халаалтын төрөл	2010		2015	
	Өрх	дүнд эзлэх хувь	Өрх	дүнд эзлэх хувь
БҮГД	24487	100	26727	100
Төвлөрсөн	625	2.6	772	2.9
Төвлөрсөн бус	186	-	224	-
Нам даралтын зуух	154	0.6	195	0.7
Цахилгаан халаагуур	32	0.1	29	0.1
Ердийн галлагаа	23676	96.7	25731	96.3

Халаалтын төрөл 2015 оны тооллогын дүнгээр



Суралцах нөхцөл

2018 - 2019 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 33 сургуулийн 654 бүлэгт 17.1 мянган хүүхэд суралцаж, 36 цэцэрлэгт 7.4 мянган хүүхэд хүмүүжиж байна. Энэ хичээлийн жилд 1-р ангид 1.9 мянган хүүхэд, 10-р ангид 1.1 мянган хүүхэд элссэний гадна 2.3 мянган хүүхэд ЕБСургуулийн дотуур байранд сууж байна. Манай аймагт эдийн засгийн чиглэлийн 1 дээд сургууль ажиллаж түүнд 64 оюутан, МУБИС-ийн салбар Багшийн сургуульд 448 оюутан суралцаж байна. Аймгийн төвийн төрийн болон хувийн хэвшлийн гурван МСҮТөвд талх нарийн боовчин, тогооч, үсчин гоо сайханч, ХАА, хүлэмжийн аж ахуйн фермерч, компьютер албан хэрэг хөтлөгч, оёдол эсгүүрчин, автомашины болон цахилгаан хэрэгслийн засварчин, сантехникч гагнуурчин, барилгын өрлөг болон засал чимэглэгч, малын бага эмч, санитори, санхүүгийн туслах ажилтан зэрэг 15 гаруй төрлийн мэргэжлээр 1421 хүүхэд суралцаж байна

Боловсролын үзүүлэлтүүд	2016	2017	2018
Ерөнхий боловсролын сургуулийн тоо	33	33	33
Бага	5	5	5
Үндсэн	7	7	7
Дунд	21	21	21
Суралцагчдын тоо	17300	17271	17191
1-5-р ангид	8564	8881	9086
6 - 9-р анги	5292	5316	5436
10-12-р анги	3444	3074	2669
Багш нарын тоо	989	982	988
Бага ангийн	325	326	325
Дунд ахлах ангийн	664	656	663
Хүүхдийн цэцэрлэгийн тоо	36	36	35
Бүлгийн тоо	242	241	231
Хүүхдийн тоо	7148	7284	7368
Багшийн тоо	220	219	215
Мэргэжлийн сургуулийн тоо	6	5	5
Суралцагчдын тоо	1835	1661	1933


Эрүүл мэндийн нөхцөл

Аймагт нийт 17 сум дундын эмнэлэгтэй, 2 сум дундын эмнэлэгт 518 ор, амбулаторийн 111 их эмчтэйгээр хүн амд үйлчилж давхардсан тоогоор 308.3 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсний 115.5 мянган хүнд урьдчилан сэргийлэх үзлэг хийж 20.8 мянган хүнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж гаргасан байна. 10000 хүнд 19 их эмч, 60 дунд мэргэжилтэн ногдож, 1 их эмчид 518 хүн ногдож байна.

Эрүүл мэндийн үзүүлэлт	2015	2016	2017	2018
Сумын эрүүл мэндийн төв	16	16	17	17
Сум дундын эмнэлэг	2	2	2	2
Их эмчийн салбар	1	1	-	-
Өрхийн эрүүл мэндийн төв	5	5	5	5
Эмнэлгийн орны тоо	511	519	518	518
Эмийн сан	39	39	39	39
Их эмчийн тоо	167	184	172	185
Дунд мэргэжилтний тоо	566	562	560	573
10000 хүнд ногдох их эмч	18	19	18	19
10000 хүнд ногдох эмнэлгийн дунд мэргэжилтэн	61	60	59	60
Төрсөн хүүхдийн тоо	2051	1957	1902	1890
Нас барсан хүний тоо	496	488	449	516

Тайлант онд 1737 эхээс 1738 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оныхоос 8.6 хувиар буюу 164 хүүхдээр бага байна. Хүн амын нас баралт 516 гарсан нь өнгөрсөн оныхоос 67 тохиолдлоор буюу 14.9 хувиар их байна. Мянган хүнд ноогдох төрөлт 18.3 , нас баралт 5.4 ноогдож хүн амын ердийн цэвэр өсөлт 12.9 промил байна.

Нас барсан хүний тоо, өвчний төрлөөр 2018 он



Аюулгүй байдал

Аймгийн хэмжээгээр 257 холбогдогч бүхий 519 гэмт хэрэг гарч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 1 хувиар буюу 5 тохиолдлоор өсөхөд хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 1.3 хувиар буюу 2 тохиолдлоор, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 1.1 хувиар өсчээ.

Гэмт хэргийн үзүүлэлт	2016	2017	2018	2018/2016%	2018/2017%
Бүртгэгдсэн хэрэг-Бүгд	536	514	519	96.8	101.0
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	174	162	176	101.1	108.6
Үүнээс:					
Хүнийг санаатай алах	4	1	4	100.0	400.0
Бусдыг болгоомжгүй алах	1			0.0	
Иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг	167	158	160	95.8	101.3
Бусдыг амиа хорлоход хүргэх	2	1	1	50.0	100.0
Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг		6	12	-	200.0
Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	8			-	-
Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг		1	1	-	100.0
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	277	262	265	95.7	101.1
Үүнээс:					
хулгай	249	229	235	94.4	102.6
дээрэм	3	3	3	100.0	100.0
залилан	19	14	26	136.8	185.7
завших, үрэгдүүлэх	6	7	1	16.7	14.3
Бусад	77	79	76	98.7	96.2

Гэмт хэргийн үзүүлэлт	2016	2017	2018	2018/2016%	2018/2017%
Гэмт хэргийн улмаас					
Насбарсан	20	31	18	90.0	58.1
Гэмтсэн	209	188	215	102.9	114.4
Учирсан хохирол/сая.төг/	2389	1358	1345	56.3	99.0
Гэмт хэрэгт холбогдогч	549	350	257	46.8	73.4
Хүүхэд	18	22	11	61.1	50.0
Эмэгтэй	45	39	29	64.4	74.4
Бүлгээр үйлдсэн	56	30	46	82.1	153.3
Согтуугаар үйлдсэн	149	99	97	65.1	98.0
18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ноогдох гэмт хэргийн тоо	90	86	86	95.6	100.0
Гэмт хэргийн илрүүлэлт /%/	63	45.9	53.1	84.3	115.7


Гэмт хэргийн улмаас 18 хүн нас барж, 215 хүн гэмтэж бэртэн улс болон иргэдэд 1345.0 сая төгрөгийн хохирол учирсан байна. Бүртгэгдсэн нийт хэргийн 8.8 хувийг бүлэглэж, 18.6 хувийг согтуугаар үйлдсэн байгаа ба зөрчил гаргасан 604 хүнийг албадан саатуулж 225 хүнийг баривчилсан байна.

Хүн ам нийгмийн үзүүлэлт

Өрх толгойлсон 2484 эмэгтэйчүүд байгаагийн 4.7 хувь нь 6 ба түүнээс дээш ам бүлийг тэжээж байна. Аймгийн хэмжээнд 1502 өнчин хүүхэд байгаагийн 6.7 хувь нь бүтэн өнчин хүүхдүүд байгаа ба нийт өнчин хүүхдийн 35 хувийг 0-9 насны хүүхдүүд эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй 3523 хүн байгаагаас 1451 нь эмэгтэй, төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй 1632 хүн байна.

Нийгмийн үзүүлэлт	2016	2017	2018	2018/2016%	2018/2017%
Нийт өнчин хүүхэд					
Бүтэн өнчин хүүхэд	121	116	101	83.5	87.1
Хагас өнчин хүүхэд	1730	1756	1401	81.0	79.8
Өрх толгойлсон эмэгтэйчүүд	2780	2734	2484	89.4	90.9
үүнээс: амбүлээр 3 хүртэл	1733	1721	1447	83.5	84.1
3-5	934	902	921	98.6	102.1
6 түүнээс дээш	113	111	116	102.7	104.5
18 хүртэл 4 ба түүнээс дээш хүүхэдтэй	1951	1971	1590	81.5	80.7
Гэрлэлт	311	440	469	150.8	106.6
Цуцлалт	44	59	52	118.2	88.1
Үрчлэлт	49	59	73	149.0	123.7

Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, жил бүрийн эцсийн байдлаар



Ашигласан материал

1. Хүн амын мэдээ-2018
2. Аймгийн Статистикийн бюллетень 2018 он
3. Хүн ам, орон сууцны тооллого-2000 он
4. Хүн ам, орон сууцны тооллого-2010 он
5. Хүн ам, орон сууцны завсрын тооллого-2015 он
6. www.nso.mn
7. www.1212.mn
8. Архангай аймгийн Статистикийн эмхэтгэл-2018